



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар A1631

Хэрлэн сум

Олимпиадад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сурагчдын чадварыг нээн хөгжүүлэх, багшийн ур чадварыг нэмэгдүүлэх, харилцан сурч, хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор зохион байгуулагдах улсын төрөлжсөн олимпиадын 2-ын давааны зардалд зориулж 4,575,000 (дөрвөн сая таван зуун далан таван мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн байгууллага иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ